



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
А.ДОРЖСҮРЭНГИЙН НЭРЭМЖИТ
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 01 сарын 04 өдөр

Дугаар А/01

Мандалговь


**Зохион байгуулалтын арга хэмжээ
авах тухай**

Улсын онцгой комиссын 2020 оны 40 дүгээр хурлын шийдвэр, аймгийн Засаг даргын 2020 оны 12 дугаар сарын 30-ний өдрийн А/383 тоот захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Коронавируст (ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах ажлын хүрээнд аймгийн хэмжээнд гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэргээс өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй хобогдуулан 2021 оны 01 дүгээр сарын 04-ний өдрөөс 03 дугаар сарын 31-ний өдрийг дуустал тус байгууллагын ажиллах цагийн хуваарийг 10:00-13:00, 14:00-17:00 болгон өөрчилсүгэй.

Хоёр. Ажлын цагийн зохицуулалттай холбогдуулан төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө болон тайлан мэдээ, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь биелүүлж ажиллахыг нийт албан хаагчид үүрэг болгосугай

ДАРГА



М.НАРАНБАДРАХ



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
А.ДОРЖСҮРЭНГИЙН НЭРЭМЖИТ
БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 02 сарын 08 өдөр

Дугаар 01/02

Мандалговь

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5, Биеийн тамир, спортын Улсын хорооны даргын А/98 тоот тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Биеийн тамир, спортын улсын хорооноос хэрэгжүүлж байгаа цахим мэдээллийн сан бүрдүүлэх, хөгжүүлэлт хийх ажлын хэсгийг 4 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Ц.Отгончулуун (Дасгалжуулагч)

Гишүүд


Б.Дашбилэг (Ахлах мэргэжилтэн)

С.Цолмон (Мэргэжилтэн)

Ё.Нэргүй (Архив, бичиг хэрэг, нярав)

2. Ажлын хэсгийн гишүүдтэй удирдамжийн дагуу гэрээ байгуулан 2017-2020 оны тэмцээн, уралдааны архивын баримт, статистик мэдээ, тамирчдын цол, зэрэг болон мэдээллийн сангийн хөгжүүлэлт хийх ажлыг үр дүнтэй зохион байгуулж, тайлан мэдээг хугацаанд нь гаргаж, холбогдох материалын хамт хүргүүлэхийг ажлын хэсгийн ахлагч (Ц.Отгончулуун)-д даалгасугай.

ДАРГА



М.НАРАНБАДРАХ



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
А.ДОРЖСҮРЭНГИЙН НЭРЭМЖИТ
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 02 сарын 08 өдөр

Дугаар А/03

Мандалговь

┌ Ахмад настанд хүндэтгэл үзүүлэх тухай ┐


Монгол Улсын Засаг, захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Ахмад настны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Байгууллагын дотоод журмын 5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Цөөвөр хэмээх төмөр үхэр жилийн сар шинийн өдрийг тохиолдуулан харъяалалын ахмадуудад хавсралтын дагуу тус бүр 100.000(Нэг зуун мянга) төгрөгний хүндэтгэл үзүүлсүгэй.

Хоёр. Ахмадуудад олгох 1,300,000 (Нэг сая гурван зуун мянга) төгрөгийг ахмадын сангаас гаргахыг нягтлан бодогч (Л.Алтанцэцэг)-т зөвшөөрсүгэй.

Гурав. Дээрхи арга хэмжээний зардлын санхүүгийн баримтыг бүрдүүлэн зохих журмын дагуу тайлагнахыг нярав Ё.Нэргүйд үүрэг болгосугай.

ДАРГА



М.НАРАНБАДРАХ



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
А.ДОРЖСҮРЭНГИЙН НЭРЭМЖИТ
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 02 сарын 24 өдөр

Дугаар A/07

Мандалговь

Цагийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Дундговь аймгийн засаг даргын 2021 оны А/67 тоот захирамж, аймгийн Онцгой комиссын 2021 оны 03 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Спорт заалны үйл ажиллагааг нээсэнтэй холбогдуулан 2021 оны 02 дугаар сарын 24-ны өдрөөс эхлэн албан хаагчдын ажиллах цагийн хуваарийг 09.00-18.00 цаг болгон өөрчилсүгэй.

Хоёр. Биеийн тамир, спортын газрын даргын 2021 оны А/01 тоот тушаалыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА



М.НАРАНБАДРАХ



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
А.ДОРЖСҮРЭНГИЙН НЭРЭМЖИТ
БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 4/05

Мандалговь

┌ Салбар ажлын хэсэг байгуулах тухай ┐

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2021 оны А/21 тоот тушаал, Дундговь аймгийн Засаг даргын 2021 оны А/67 тоот тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Биеийн тамир, спортын үйл ажиллагаанд коронавируст (КОВИД-19) халдвараас сэргийлэх салбар ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч С.Цолмон (Нийтийн биеийн тамир, спорт хариуцсан мэргэжилтэн)

Д.Болор-Эрдэнэ (Волейболын дасгалжуулагч)

Ц.Отгончулуун (Таеквондогийн дасгалжуулагч)

Хоёр. Удирдамжийн дагуу салбар ажлын хэсэг үйл ажиллагааны төлөвлөгөө гарган батлуулж, хэрэгжүүлэх, хуваарийн дагуу тайлан мэдээг Биеийн тамир, спортын улсын хороонд өдөр бүрийн 09.00 цагт хүргүүлэхийг ажлын хэсгийн ахлагч (С.Цолмон)-д үүрэг болгосугай.

Гурав. Салбар ажлын хэсгийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Хүний нөөц, хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод ажил хариуцсан ахлах мэргэжилтэн (Б.Дашбилэг)-т даалгасугай.

ДАРГА



М.НАРАНБАДРАХ



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
А.ДОРЖСҮРЭНГИЙН НЭРЭМЖИТ
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 03 сарын 03 өдөр

Дугаар А/06


Мандалговь

Биеийн тамир, спортын мэдээллийн
цахим сан бүрдүүлэх ажлын хөлс олгох тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.8 дахь заалт, Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2020 оны 12 дугаар сарын 18-ны А/98 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Биеийн тамир, спортын мэдээллийн цахим сан бүрдүүлэлтийн ажлыг гэрээний дагуу гүйцэтгэсэн салбар ажлын хэсгийн гишүүдэд тус бүр 500,000(Таван зуун мянга) төгрөгийг олгосугай.
2. Салбар ажлын хэсгийн гишүүдэд гэрээний дагуу олгох 2,000,000(Хоёр сая) төгрөгийг нэмэлт санхүүжилтийн данснаас гаргахыг нягтлан бодогч (Л.Алтанцэцэг)-т зөвшөөрсүгэй.
3. Биеийн тамир, спортын улсын хороонд гэрээгээр ажил гүйцэтгүүлэн хөлс төлсөн санхүүгийн баримтыг бүрдүүлж хүргүүлэхийг нягтлан бодогч (Л.Алтанцэцэг)-т үүрэг болгосугай.

ДАРГА



М.НАРАНБАДРАХ



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
А.ДОРЖСҮРЭНГИЙН НЭРЭМЖИТ
БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 03 сарын 03 өдөр

Дугаар А/07

Мандалговь

Сургалт, ажиллах нөхцөл,
нийгмийн баталгааны хөтөлбөрийг батлах тухай

Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3 дэхь хэсэг, Монгол улсын Засгийн газрын 1999 оны 96 дугаар тогтоолыг үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.
2. Хөтөлбөрийг ажлын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж ажиллахыг нийт албан хаагчдад үүрэг болгосугай.
3. Хөтөлбөр хэрэгжүүлэх жилийн төлөвлөгөөнд зарцуулах зардлыг жил бүрийн байгууллагын төсөвт тусгахыг нягтлан бодогч (Л.Алтанцэцэг)-т, Хөтөлбөрийн төлөвлөгөө, хэрэгжилтийг гарган ажиллахыг ахлах мэргэжилтэн (Б.Дашбилэг) даалгасугай.

ДАРГА



М.НАРАНБАДРАХ